



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 4/11

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Аймгийн онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар хуралдааны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19) цартахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх шинжилгээнд шаардагдах 1000 (нэг мянга) ширхэг түргэвчилсэн оношлуурын зардалд 14,161,916 (арван дөрвөн сая нэг зуун жаран нэгэн мянга есөн зуун арван зургаа) төгрөг зарцуулсугай.
2. Түргэвчилсэн оношлуурын зардал 14,161,916 (арван дөрвөн сая нэг зуун жаран нэгэн мянга есөн зуун арван зургаа) төгрөгийг Эрүүл мэндийн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжүүлтээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.
3. Түргэвчилсэн оношлуурын захиалгыг Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого хэрэгжилтийн газарт хүргүүлэн худалдан авалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар /Д.Шивааннүрдэв/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100246

D:My Doc. Zahiramj. Zasag darga